



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ  
ХУУЛИЙН 2025 ОНЫ I УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮР ДҮН

УДИРДАМЖИЙН КОД: №02

I ДҮГЭЭР УЛИРАЛ



22/04/2025

# Хяналт шалгалтын объект

## АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын газар

## АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Төсвийн ерөнхийлөн захирагч 1, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 17, Орон нутгийн хөгжлийн сангийн 18, Хоршоо хөгжүүлэх сангийн 17, төсвийн шууд захирагчийн 52, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 23 нийт 128 нэгж хамрагдав.

## АУДИТЫН ТӨРӨЛ

Нийцлийн аудит

## АУДИТ ХИЙХ ХУГАЦАА

2025.04.10-2025.04.22

## АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН

Дотоод аудитор Г.Дорждэрэм  
Дотоод аудитор Д.Ванчигмаа



Тайлан баталгаажуулсан:  
Санхүүгийн хяналт, дотоод  
аудитын газрын дарга СХШУАБ  
Т.Одсүрэн

Тайлан бэлтгэсэн:  
Дотоод аудитор  
Г.Дорждэрэм, Л.Ванчигмаа

Аудитын тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал

[selenge@sankhuuaudit.se.gov.mn](mailto:selenge@sankhuuaudit.se.gov.mn)

д мэйл хаягаар харилцана уу.

ХАЯГ: Сүхбаатар сум Орхон 6  
дугаар баг, Нутгийн  
удирдлагын II ордон, 1 давхар  
2025 оны 04 дүгээр сар

## АГУУЛГА

### 1. ТАНИЛЦУУЛГА

### 2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

- 2.1 Аудитын зорилго
- 2.2 Аудитын цар хүрээ, хязгаарлалт
- 2.3 Аудитын арга зүй

### 3. АУДИТЫН ҮР ДҮН

- 3.1 Илэрсэн асуудлууд

### 4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 1. ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын үйл ажиллагааны 2024 оны дотоод аудит хийх төлөвлөгөөний дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 128 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн 2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтын үр дүнд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Тухайн хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 128 байгууллага нэгжийн шилэн дансны цахим цэсэд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 5,648 мэдээллийг жил, улирал, сар, тухай бүр гэсэн хугацаанд байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээлэл бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн байх шаардлагатай.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллээ байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан эсэхэд дүгнэлт хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-3.2 дахь хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагууд хуульд заасан мэдээллийг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1-д “*Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын газарт дараа сарын 15-ны дотор тайлагнана*” гэж заасны дагуу 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн байдалд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 128 байгууллагад нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ

### 2.3 Аудитын арга, зүй

Аудитыг гүйцэтгэхэд ДАМПОУС 1100, 2200-2450 дугаар стандарт, “Улсын салбарын байгууллагад дотоод аудит хийх аргачлал”-ын баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжийн шилэн дансны цахим хуудаст байрлуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

## 2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

## 2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, дотоод аудитор Г.Дорждэрэм аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлж, дотоод аудитор Д.Ванчигмаа нар гүйцэтгэв.

### ГУРАВ: АУДИТЫН ҮР ДҮН

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, харьяа 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 52 төсвийн байгууллага, 23 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 35 тусгай сан, нийт **128** байгууллагыг хамруулан, аудитыг гүйцэтгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас 2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар нийт **5,648** мэдээлэл байршуулахаас **5.523** мэдээлэл байршуулж **125** мэдээллийг огт байршуулаагүй, **180** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, **3** мэдээллийн цэсийг сонгож нээгээгүйгээс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж **94.6** хувьтай тайлагнагдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтын үр дүнг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 1.

№	Байгууллагын нэрс	Мэдээлэл байршуулах байгууллагын тоо	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон мэдээллийн тоо	Мэдээлээгүй тоо	Нийт хэрэгжилтийн хувь
1	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	45	45	34	11	0	75.6
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	1	45	45	40	5	0	88.9
3	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	42	42	42			100.0
4	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	42	42	40	2	0	95.2
5	Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	45	45	45			100.0
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	1	45	45	45			100.0
7	Орон нутгийн өмчийн газар	1	45	45	45			100.0
8	Худалдан авах ажиллагааны газар	1	45	45	39	6		86.7
9	Алтанбулаг сумын дүн	5	219	219	203	16	0	92.7
10	Баруунбүрэн сумын дүн	5	219	219	216	3	0	98.6
11	Баянгол сумын дүн	5	222	222	216	6	0	97.3
12	Ерөө сумын дүн	6	267	267	255	12	0	95.5
13	Жавхлант сумын дүн	5	222	222	222	0	0	100.0
14	Зүүнбүрэн сумын дүн	5	219	219	208	11	0	95.0
15	Мандал сумын дүн	7	303	303	295	8	0	97.4
16	Орхон сумын дүн	5	216	216	207	9	0	95.8
17	Орхонтуул сумын дүн	6	261	261	232	29	0	88.9
18	Сайхан сумын дүн	7	306	306	301	5	0	98.4
19	Сант сумын дүн	5	216	216	209	7	0	96.8
20	Сүхбаатар сумын дүн	5	219	219	215	4	0	98.2
21	Түшиг сумын дүн	5	216	216	208	8	0	96.3
22	Хушаат сумын дүн	5	216	216	214	2	0	99.1
23	Хүдэр сумын дүн	5	216	215	208	7	1	96.3
24	Цагааннуур сумын дүн	5	216	216	216	0	0	100.0

25	Шаамар сумын дүн	6	261	261	252	9	0	<b>96.6</b>
26	Ойн ангийн дүн	5	222	222	221	1	0	<b>99.5</b>
27	ОНӨААТҮГ-ын дүн	23	1058	934	915	19	124	<b>86.5</b>
<b>Нийт дүн</b>		<b>128</b>	<b>5648</b>	<b>5523</b>	<b>5343</b>	<b>180</b>	<b>125</b>	<b>94.6</b>

<b>Илэрсэн асуудал 1</b>	ТТЗ-ийн түвшинд шилэн дансны мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, болон ОНХС, ХХС-ийн шилэн дансны цэсийг нээж бүртгүүлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал:	
<ol style="list-style-type: none"> <li>Сэлэнгэ аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 45 мэдээлэл байршуулахаас 34 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 11 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 75.6%-тай</li> <li>Сэлэнгэ аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 45 мэдээлэл байршуулахаас 40 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 5 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 88.9%-тай</li> <li>Алтанбулаг сумын хэмжээнд 5 байгууллага 219 мэдээлэл байршуулахаас 203 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 16 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 92.7%-тай</li> <li>Баруунбүрэн сумын хэмжээнд 5 байгууллага 219 мэдээлэл байршуулахаас 216 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 98.6%-тай</li> <li>Баянгол сумын хэмжээнд 5 байгууллага 222 мэдээлэл байршуулахаас 216 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 6 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 97.3%-тай</li> <li>Ерөө сумын хэмжээнд 6 байгууллага 267 мэдээлэл байршуулахаас 255 мэдээлэл байршуулж 12 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 95.5%-тай</li> <li>Жавхлант сумын хэмжээнд 5 байгууллага 222 мэдээлэл байршуулахаас 222 мэдээлэл хугацаанд нь байршуулж мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай</li> <li>Зүүнбүрэн сумын хэмжээнд 5 байгууллага 219 мэдээлэл байршуулахаас 208 мэдээлэл байршуулж, 11 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 95.0%-тай</li> <li>Мандал сумын хэмжээнд 7 байгууллага 303 мэдээлэл байршуулахаас 295 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 97.4%-тай</li> <li>Орхон сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 207 мэдээлэл хугацаанд нь байршуулж 9 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 95.8%-тай</li> <li>Орхонтуул сумын хэмжээнд 6 байгууллага 261 мэдээлэл байршуулахаас 232 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 29 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 88.9%-тай</li> <li>Сайхан сумын хэмжээнд 7 байгууллага 306 мэдээлэл байршуулахаас 301 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 5 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 98.4%-тай</li> <li>Сант сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 209 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 7 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.8%-тай</li> </ol>	

<p>14. Сүхбаатар сумын хэмжээнд 5 байгууллага 219 мэдээлэл байршуулахаас 215 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан мэдээлэл байршуулалтын хувь 98.2%-тай</p> <p>15. Түшиг сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 208 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.3%-тай</p> <p>16. Хушаат сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 214 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 99.1%-тай</p> <p>17. Хүдэр сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 208 мэдээлэл хугацаанд нь байршуулж 1 мэдээлэл огт байршуулаагүй, 7 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.3%-тай</p> <p>18. Цагааннуур сумын хэмжээнд 5 байгууллага 216 мэдээлэл байршуулахаас 216 мэдээлэл хугацаанд нь байршуулсан мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай</p> <p>19. Шаамар сумын хэмжээнд 6 байгууллага 261 мэдээлэл байршуулахаас 252 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 9 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.6%-тай</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: 2024 оны 1-р улирлын байдлаар ТЕЗ, ТТЗ, ТШЗ, Тусгай сан, ОНӨААТҮГ-ын нийт 5,687 мэдээллийг сар, улирал, тухайн үед гэсэн хугацаанд ангиллаар байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээлэл бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн байх шаардлагатай</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй</li> <li>- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,</li> <li>- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр нөлөөлөх</li> </ul>
<p>Зөвлөмж:</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.</p>

2. Ой ангийн 5 газрууд нь тухайн хугацаанд 222 мэдээлэл байршуулахаас 221 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, нийт мэдээлэл байршуулалт 99.5%-тай дүгнэгдэж байна.

3. ОНХС, ХХС-ийн 35 газрууд нь тухайн хугацаанд 1,524 мэдээлэл байршуулахаас 1469 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 55 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, нийт мэдээлэл байршуулалт 96.4%-тай дүгнэгдэж байна.

4. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь тухайн хугацаанд 1022 мэдээлэл байршуулахаас 869 мэдээлэл байршуулж 153 мэдээллийг огт байршуулаагүй, 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээлэл байршуулалт 83.2%-тай дүгнэгдэж байна.

<b><u>Илэрсэн асуудал 3</u></b>	Шилэн дансны цахим хуудсанд хангалтгүй мэдээлэл байршуулсан ОНӨААТҮГ-ууд
Асуудлын ангилал	Нөлөө багатай

Бодит байдал:

1. Илдэн бүрэн ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 44 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 95.7%-тай
2. Мандал Энерго ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 45 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
3. Тохилог Хараа ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 21 мэдээлэл байршуулж, 25 мэдээллийг огт байршуулаагүй, мэдээлэл байршуулалтын хувь 45.7%-тай
4. Өргөн Сэлэнгэ ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 46 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
5. Гавшгай Ус ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 39 мэдээлэл байршуулж, 7 мэдээлэл огт байршуулаагүй, мэдээлэл байршуулалтын хувь 84.8%-тай
6. Цэнгэг-Ус ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 45 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
7. Хүдэр тохижилт ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 44 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 95.7%-тай
8. Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 45 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
9. Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 41 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 5 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 89.1%-тай
10. Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 45 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
11. Хүдэр ой анги ОНӨААТҮГ нь 46 мэдээлэл байршуулахаас 44 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 95.7%-тай
12. Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ 46 мэдээлэл байршуулахаас 45 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
13. Мандал шинэ агротехник, Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ-ууд нь 46 мэдээлэл байршуулахаас огт байршуулаагүй, мэдээлэл байршуулалтын хувь 0%-тай
14. Энхмэнд сувилал, Цант Орхон, Туулын хишиг, Баянгол сумын Баянгол сувилал, “Сэлэнгэ-Үржлийн Цөм Сүргийн Аж Ахуй”, Сэлэнгэ барилга захиалагч, Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ, Цагааннуур тохижилт, Хушаат дуут хад ОНӨААТҮГ-уудын мэдээлэл байршуулалтын хувь 100%-тай

Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Шилэн дансны тухай хуульд заасан 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар нь шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлнэ.

Асуудлын үндсэн шалтгаан: Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,
- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр

нөлөөлөх

Зөвлөмж:

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Шилэн дансны тухай хуульд заасан 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2. төрийн өмчит үйлдвэрийн газар нь шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасны дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.

#### 4.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас харьяа нийт 128 байгууллага нэгжид “Шилэн дансны тухай” хууль, Загийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд 2025 оны 1-р улирлын байдлаар 94.6 хувьтай буюу “**Хангалттай**” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалттай	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үй явцын төлөвшил нь “давтамжтай буюу 3-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 20% хүртэл нь “нөлөө ихтэй” гэж үзсэн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтын дүгнэлтийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 2.

Байгууллагын нэр	Мэдээлэл байршуулах байгууллагын	Хэрэгжилтийн хувь /1-р улирал/	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	75.6	Хангалтгүй	Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн.
Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	1	88.9	Сайжруулах шаардлагатай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байх хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулалтын сайжруулах шаардлагатай
Худалдан авах ажиллагааны газар	1	86.7	Сайжруулах шаардлагатай	
Орхонтуул сумын дүн	6	88.9	Сайжруулах шаардлагатай	
ОНӨААТҮГ-ын дүн	23	86.5	Сайжруулах шаардлагатай	

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	95.2	Хангалттай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод байдлыг ханган ажилласан.
Алтанбулаг сумын дүн	5	92.7	Хангалттай	
Баруунбүрэн сумын дүн	5	98.6	Хангалттай	
Баянгол сумын дүн	5	97.3	Хангалттай	
Ерөө сумын дүн	6	95.5	Хангалттай	
Зүүнбүрэн сумын дүн	5	95.0	Хангалттай	
Мандал сумын дүн	7	97.4	Хангалттай	
Орхон сумын дүн	5	95.8	Хангалттай	
Сайхан сумын дүн	7	98.4	Хангалттай	
Сант сумын дүн	5	96.8	Хангалттай	
Сүхбаатар сумын дүн	5	98.2	Хангалттай	
Түшиг сумын дүн	5	96.3	Хангалттай	
Хушаат сумын дүн	5	99.1	Хангалттай	
Хүдэр сумын дүн	5	96.3	Хангалттай	
Шаамар сумын дүн	6	96.6	Хангалттай	
Ойн ангийн дүн	5	99.5	Хангалттай	
Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	100.0	Хангалттай	
Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	100.0	Хангалттай	
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	1	100.0	Хангалттай	
Орон нутгийн өмчийн газар	1	100.0	Хангалттай	
Жавхлант сумын дүн	5	100.0	Хангалттай	
Цагааннуур сумын дүн	5	100.0	Хангалттай	
<b>Нийт дүн</b>	<b>128</b>	<b>94.6</b>		

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “*үнэн зөв, бодиттой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1-6.5 заасан хугацааг хоцроосон, огт мэдээлээгүй зөрчил илэрсэн байна.

Иймд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай ОНӨААТҮГ-ын 1, ТТЗ-ийн 12, ТШЗ-ийн 6 эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “*Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах*”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “*Дотоод аудитын дүрэм*”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “*Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.*” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх

хугацаатай албан шаардлага, болон хариуцлага тооцох үндэслэл бүрдэж байгаа тул цаашид төсвийн ил тод байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх ажиллах чиглэлээр энэ шалгалтын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, НЯГТЛАН БОДОГЧ НАРТ ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ НЬ**

1. Шилэн дансны тухай хуулийн 8.4-т “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.
2. Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, оруулж байх.
3. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” 8.1-д заасан Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын газарт дараа сарын 15-ны дотор тайлагнаж байх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд дараагийн улирлаас хариуцлага тооцох арга хэмжээг авахыг бүх шатны төсвийн захирагч нарт тус тус зөвлөмжөөр хүргүүлж байна.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

ДОТООД АУДИТОР




Г.ДОРЖДЭРЭМ

Д.ВАНЧИГМАА

БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА



Т.ОДСҮРЭН